



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар Б/33

Хэрлэн сум

О.Баяртөгсийг хавсран
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, "Хэнтий орон сууц" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хэнтий орон сууц" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын менежер Очирпүрэвийн Баяртөгсийг 2022 оны 6 дугаар сарын 6-аас эхлэн "Хэнтий орон сууц" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг хавсран гүйцэтгэгчээр томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Коммисын

дарга: Э.Мөнх-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Э.Даваажав "Хэнтий орон сууц" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын менежер Нягтлан бодогч, бичиг хэрэг

3.О.Баяртөгсөд "Хэнтий орон сууц" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Даваажав)-д зөвшөөрсүгэй.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллахыг О.Баяртөгсөд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010649